



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/151

Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай, хаяг  
өөрчлөх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэр 24 айлын орон сууцны өргөтгөлийн 1 тоотод байрлах "Сэтэр хүрэн" /2352036/ 70 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 61 метр квадрат, Амарсанаагийн 1 дүгээр гудамжны 105 а тоот болгон үйлчилгээний зориулалтаар 9 жилийн хугацаагаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2. Газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/151 Ch  
02 00708